



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/539

Мөрөн сум

Өвсний үнэ олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 -ын "а", аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 78 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2020 оны хавар Хөвсгөл аймгийн нийт нутгаар цасан бүрхүүл тогтож, зарим сумдад өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан Ховд аймгаас Жаргалант суманд 966 боодол өвс, Шинэ-Идэр суманд 960 боодол өвс нийлүүлсний үлдсэн төлбөр болох 9630000 төгрөгийг (Есөн сая зургаан зуун гучин мянган) аймгийн Мал хамгаалах сангаас гаргаж зарцуулсугай.

2. Өвсний үнийн тооцоог хийж ажиллахыг Мал хамгаалах сангийн нягтлан бодогч (Я.Баянжаргал)-д үүрэг болгосугай.

3. Сумдад олгосон өвсний үнийн олгох ажилд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д даалгасугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД